



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 23 өдөр

Дугаар A/75

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гишүүн "Зэт Жи Би УЦК" ХХК-ийн ажилтан Д.Энххишигийн арилжаанд оролцох эрхийг 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн цуцалж, тус компанийн гүйцэтгэх захирал Г.Болормаад үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн УЦК-уудад Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ



000404